



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ ТӨХХК-ИЙН 2020
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2021/85/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор Д.Эрдэнэчимэг
Утас: 260512 Цахим хаяг: erdenechimegn@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: "Ихмонгол хөлөг Аудит" ХХК
Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn

Улаанбаатар хот
2021 он

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	11
3.Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	15
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа	16
3.8. Шилэн дансны мэдээлэл	16
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.10. Аудитын илрүүлэлт.....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	17
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ
БУУДАЛ ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Л.ЦЭНГҮҮНЖАВ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12 дугаар сарын 31	2020 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	10,133,255,619.88	673,109,872.62
1.1.2	Дансны авлага	526,666.67	-
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	5,569,596.00	10,757,575.82
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	9,374,816.00	22,435,905.36
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	10,148,726,698.55	706,303,353.80
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	213,077,455.17	330,278,502.82
1.2.2	Биет бус хөрөнгө	-	1,187,638.33
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	35,290,578,514.07	48,407,494,354.07
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	35,503,655,969.24	48,738,960,495.22
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	45,652,382,667.79	49,445,263,849.02
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,168,891.28	1,163,891.28
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	210,473.72	5,086,854.06
2.1.1.4	НДШ – ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүгийн өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,379,365.00	6,250,745.34
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-

**Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2020 оны
санхүүгийн тайлангийн аудит**

2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,379,365.00	6,250,745.34
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,000,000.00	1,000,000.00
2.3.2	Хувийн	-	-
2.3.3	Хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	45,272,410,521.60	48,729,038,901.60
2.3.9	Хуримтлагдсан ашиг	377,592,781.19	708,974,202.08
2.3.11	Эздийн өмчийн дүн	45,651,003,302.79	49,439,013,103.68
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	45,652,382,667.79	49,445,263,849.02

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг(алдагдал)	-	-
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	693,950,378.49	106,659,003.11
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	461,157,182.00	791,134,605.16
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	544,229,029.08	728,411,734.08
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	3,982.54	199,322,176.84
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	610,882,513.95	368,704,051.03
19	Орлогын татварын зардал	69,395,037.69	37,322,630.14
20	Татварын дараах ашиг (алдагдал)	541,487,476.26	331,381,420.89
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	541,487,476.26	331,381,420.89
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	/төгрөгөөр/
				Нийт дүн
2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.00	27,625,446,000.00	(163,894,695.07)	27,462,551,304.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	27,625,446,000.00	(163,894,695.07)	27,462,551,304.93
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	17,646,964,521.60	-	17,646,964,521.60
Зарласан ногдол ашиг	-	-	541,487,476.26	541,487,476.26
2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.00	45,272,410,521.60	377,592,781.19	45,651,003,302.79
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	1,000,000.00	45,272,410,521.60	377,592,781.19	45,651,003,302.79
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	331,381,420.89	331,381,420.89
Өмчид гарсан өөрчлөлт	-	3,456,628,380.00	-	3,456,628,380.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
2020 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.00	48,729,038,901.60	708,974,202.08	49,439,013,103.68

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	18,108,746,217.60	4,249,957,048.34
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого	17,646,964,521.60	3,456,628,380.00
	Бусад мөнгөн орлого	461,781,696.00	793,328,668.34
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	594,986,072.04	736,455,995.55
	Ажиллагчдад төлсөн	214,810,162.85	350,595,214.74
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	66,572,074.79	91,256,672.76
	Бараа материал худалдан авахад төлсөн	21,944,764.00	44,446,126.34
	Ашиглалтын зардалд төлсөн	74,194,000.00	124,687,080.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,374,482.00	3,434,769.00
	Хүүгийн төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	96,666,176.77	67,176,143.39
	Даатгалын төлбөрт төлсөн	1,260,000.00	2,682,096.00
	Бусад мөнгөн зарлага	109,164,411.63	52,177,893.32
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	17,513,760,145.56	3,513,501,052.79
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	693,950,378.49	106,659,003.11
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүгийн орлого	693,950,378.49	106,659,003.11
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	35,309,558,230.07	13,279,627,980.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	18,979,716.00	161,392,140.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	1,320,000.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	35,290,578,514.07	13,116,915,840.00
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(34,615,607,851.58)	(13,172,968,976.89)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-

**Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2020 оны
санхүүгийн тайлангийн аудит**

	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	3,982.54	199,322,176.84
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(17,101,843,723.48)	(9,460,145,747.26)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,235,099,343.36	10,133,255,619.88
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,133,255,619.88	673,109,872.62

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2019 оны гүйцэтгэл	2020 он		дүн	Хувь /төгрөг/
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
		НИЙТ ОРЛОГО	1,155,111,543.03		
Засгийн газрын санхүүжилт	461,059,000.00	1,224,737,000.00	790,500,000.00	-434,237,000.00	64.5
Үндсэн үйл ажиллагааны орлого	-	-	-	-	-
Хүүгийн болон бусад орлого	694,048,560.49	-	107,293,608.27	107,293,608.27	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	3,982.54	-	199,322,176.84	199,322,176.84	-
Хүндэт зочны танхимын үйлчилгээний орлого	-	274,725,000.00	-	-274,725,000.00	-
НИЙТ ЗАРДАЛ	544,229,029.08	1,460,731,000.00	728,411,734.08	-732,411,734.08	49.9
Үндсэн үйл ажиллагааны зардал	544,229,029.08	1,028,037,000.00	728,411,734.08	-299,625,265.92	70.9
Хүндэт зочны танхимын үйлчилгээний зардал	-	432,694,000.00	-	-432,694,000.00	-
Үндсэн үйл ажиллагааны ашиг	610,882,513.95	38,731,000.00	368,704,051.03	329,973,051.03	952.0
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг	-	-	-	-	-
НИЙТ АШИГ, АЛДАГДАЛ	610,882,513.95	38,731,000.00	368,704,051.03	329,973,051.03	952.0
Орлогын албан татвар	69,395,037.69	3,873,100.00	37,322,630.14	33,449,530.14	963.6
Цэвэр ашиг	541,487,476.26	34,857,900.00	331,381,420.89	296,523,520.89	950.7
Ногдол ашиг	-	3,485,790.00	-	-	-
Авлага	526,666.67	1,000,000.00	-	-1,000,000.00	-
Өглөг	1,379,365.00	5,000,000.00	6,250,745.34	1,250,745.34	125.0
Урт хугацаат	-	-	-	-	-
Богино хугацаат	1,379,365.00	5,000,000.00	6,250,745.34	1,250,745.34	125.0
Цалингийн сан	310,579,066.55	585,840,000.00	427,610,234.43	-158,229,765.57	73.0
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.47	0.97	0.66	-0.41	68.0
Элэгдэл	33,740,411.88	48,608,000.00	44,523,454.02	-4,084,545.98	91.6
Хөрөнгө оруулалт	18,979,716.00	534,836,000.00	162,912,140.00	-371,923,860.00	30.5
Ажиллагсдын тоо	13	35	14	-21	40.0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг захирал Л.Цэнгүүнжав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн баримтын цахим бүртгэлийн хяналтыг сайжруулах, шилэн дансны хуулийг мөрдөж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 25-наас 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн захирал С.Тунгалаг хянан удирдаж ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Дэлгэрцог, аудитын менежер Б.Батцэцэг, аудитын шинжээч Т.Оюун, аудиторын туслах Г.Ариунболд нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2020 оны санхүүгийн тайланг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 01/16 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани статустай байна. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 150 дугаар тогтоолын 1-т “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн Монголын талд ногдох 49 хувийг эзэмших “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК байгуулсугай. 3-т Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн Монголын талд ногдох хувь, “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Зам тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг томилсугай” гэж заасны дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн дүрэмд тус байгууллагын зорилтыг “Нисэх буудлаар үйлчлүүлэгчдэд олон улсын стандарт, шаардлагын түвшинд хүрсэн, аюулгүй байдлыг бүрэн хангасан, тав тухтай нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх, нисэх буудлын хэвийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, галын болон аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах замаар Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлж, ашигтай ажиллагааг хангах” гэж тодорхойлжээ.

Үндсэн зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааны чиглэлийг тусгажээ. Үүнд:

- Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын төрийн үйлчилгээний Хүндэт зочны танхим /586 кв.м/-ын үйл ажиллагааг эрхлэх;
- Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал дахь агаарын хөлгийн ангарын болон бусад барилга байгууламжийн менежментийг хэрэгжүүлэх;

- Хамтарсан компанид ашиглуулахаас бусад нисэх буудлын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах;
- Тусгай хэрэгцээний газрыг Хувьцаа эзэмшигчээс эрх олгосноор газар ашиглах гэрээ байгуулах;
- Өөрийн болон хамтарсан компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүй, хамааралгүй нисэх буудлын үйл ажиллагааны чиглэлээр бизнесийн болон менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- Хамтарсан компанийн үйл ажиллагаанд хамааралгүй “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал”-ын бусад үйл ажиллагаа.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.5-д “Гамшгийн онц нөхцөл байдал зарласан, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол; /Энэ заалтад 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д” Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”; (2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн)
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д” Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 10-аас доошгүй жил хадгална”;(2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.)
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Засгийн газрын 2020 оны 227 дугаар тогтоол (Үйл ажиллагаа эхлэх хугацааг хойшлуулах тухай)
- Засгийн газрын 2020 оны 134 дүгээр тогтоол (Тогтоолд өөрчлөлт оруулах тухай)

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өмнөх оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн суурь үзүүлэлт нийт зардал 613.6 сая төгрөгөөс 1 хувиар тооцож 6.1 сая төгрөгөөр тогтоож баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тайлант оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн суурь үзүүлэлт нийт зардал 765.7 сая төгрөгөөс 1 хувиар тооцож 7.7 сая төгрөгөөр тогтоолоо.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,792.9 сая төгрөгөөр буюу 8.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урт хугацаат үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалт, эздийн өмчийн бусад хэсгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10,133.3	673.1	(9,460.1)
Бусад авлага	0.5	-	(0.5)
Бараа материал	5.6	10.8	5.2
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	9.4	22.4	13.1
Эргэлтийн хөрөнгийн дүн	10,148.7	706.3	(9,442.4)
Үндсэн хөрөнгө	213.1	330.3	117.2
Биет бус хөрөнгө	-	1.2	1.2
Урт хугацаат хөрөнгө оруулалт	35,290.6	48,407.5	13,116.9
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	35,503.7	48,739.0	13,235.3
Нийт хөрөнгийн дүн	45,652.4	49,445.3	3,792.9
Дансны өглөг	1.2	1.2	-
Татварын өр	0.2	5.1	4.9
Өр төлбөрийн нийт дүн	1.4	6.2	4.9
Төрийн өмч	1.0	1.0	-
Эздийн өмчийн бусад хэсэг	45,272.4	48,729.0	3,456.6
Хуримтлагдсан ашиг	377.6	709.0	331.4
Эздийн өмч	45,651.0	49,439.0	3,788.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	45,652.4	49,445.3	3,792.9

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 673.1 сая төгрөг болж 9,460.1 сая төгрөгөөр буурсан нь Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудлын менежмент төслийг хэрэгжүүлэх Монгол, Япон талын хамтарсан хуулийн этгээдэд хоёр дахь ээлжийн 13,116.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэнтэй холбоотой байна.

Урьдчилж төлсөн зардал/тооцоо дансны үлдэгдэл 22.4 сая төгрөг болж 13.1 сая төгрөгөөр өссөн нь 2020 оны санхүүгийн тайлангийн аудитын төлбөр 11 сая төгрөг, түрээс 1.1 сая төгрөг, автомашины даатгалын төлбөр 0.9 сая, шатахууны картын үлдэгдэл 0.1 сая төгрөгийн төлбөрийг урьдчилж шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 330.3 сая төгрөг болж 117.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 162.7 сая төгрөгийн биет болон биет бус хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 48,407.5 сая төгрөг болж 13,116.9 сая төгрөгөөр өссөн нь Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудлын менежмент төслийг хэрэгжүүлэх Монгол, Япон талын хамтарсан хуулийн этгээдэд хоёр дахь ээлжийн 13,116.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэнтэй холбоотой байна.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 48,729.0 төгрөг болж 3,456.6 сая төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2019 оны 175 дугаар тогтоолын дагуу Иргэний нисэхийн ерөнхий газраас Нью Улаанбаатар интернэшнл эйрпот ХХК-ийн 49 хувийг эзэмших зориулалтаар шилжүүлсэн хөрөнгө оруулалттай холбоотой байна.

3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2-т заасны дагуу Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ХЭХТ-19/07 дугаар тогтоолоор 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,499.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,460.7 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 34.9 сая төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 1,097.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 765.7 сая төгрөгийн зардал гарган, 331.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Орлогын эх үүсвэр нь Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүжилт 790.5 сая төгрөг, хүүгийн орлого 106.9 сая төгрөг, тендерийн баримт бичгийн үнэ 0.6 сая төгрөг, гадаад валютын ханшийн зөрүүний олз 199.3 сая төгрөгөөс тус тус бүрджээ.

Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2019 оны гүйцэтгэл	2020 он		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	гүйцэтгэлийн зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО	1,155.1	1,499.5	1,097.1	- 402.4	73.0
Засгийн газрын санхүүжилт	461.1	1,224.7	790.5	- 434.2	65.0
Үндсэн үйл ажиллагааны орлого	-	-	-	-	-
Хүүгийн болон бусад орлого	694.0	-	107.3	107.3	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.0	-	199.3	199.3	-
Хүндэт зочны танхимын үйлчилгээний орлого	-	274.7	-	- 274.7	-
НИЙТ ЗАРДАЛ	544.2	1,460.7	728.4	- 732.4	50.0
Үндсэн үйл ажиллагааны зардал	544.2	1,028.0	728.4	- 299.6	71.0
Хүндэт зочны танхимын үйлчилгээний зардал	-	432.7	-	- 432.7	-
Үндсэн үйл ажиллагааны ашиг	610.9	38.7	368.7	330.0	952.7
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг	-	-	-	-	-

НИЙТ АШИГ, АЛДАГДАЛ	610.9	38.7	368.7	330.0	952.7
Орлогын албан татвар	69.4	3.9	37.3	33.4	956.4
Цэвэр ашиг	541.5	34.9	331.4	296.5	949.6

Нийт орлогын гүйцэтгэл 1,097.1 сая төгрөг болж төлөвлөснөөс 402.4 сая төгрөг буюу 26.8 хувиар тасарсан нь Иргэний нисэхийн ерөнхий газраас 434.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон, Засгийн газрын 2020 оны 227, 134 дүгээр тогтоолуудаар Үйл ажиллагаа эхлэх хугацааг хойшлуулснаас хүндэт зочны танхимын үйлчилгээний орлого 274.7 сая төгрөгийн орлого тасарснаас шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 765.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 695.0 сая төгрөг буюу 47.6 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2020 оны 227, 134 дүгээр тогтоолуудаар Үйл ажиллагаа эхлэх хугацааг хойшлуулснаас үндсэн үйл ажиллагааны зардал буурснаас шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 150 дугаар тогтоолын 3-т Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн Монголын талд ногдох хувь, "Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Зам тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг томилсугай." гэж заасны дагуу Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ХЭХТ-20/01 дүгээр тогтоолоор компанийн дүрмийг шинэчлэн баталсан байна.

"Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК-ийн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.5-д "...Хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь Зам, тээврийн хөгжлийн яам нийт хувьцааны 66.0 (жаран зургаан) хувь, (цаашид "Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага" гэх), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 34.0 (гучин дөрвөн) хувь (цаашид "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэх) байна..." компанийн дүрэмд заасан үйл ажиллагааг явуулж байна.

3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 161 мэдээлэл, хугацаа болоогүй 1 мэдээлэл, хугацаа хоцроосон 9 мэдээлэл байна.

3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/Сая төгрөг/

/сая.төг/Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	1	-	1	-	100.0

Тус компанийн 2019 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын тайланд "...Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Маягт, заавар батлах тухай" журмыг тус тус мөрдөж ажиллах" зөвлөмж өгснийг дагуу санхүүгийн программд дээрх хууль, журамд заасан нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, маягыг шинэчлэн оруулж, нягтлан бодох бүртгэлийг батлагдсан маягт, зааврын дагуу хөтөлж ажилласан байна.

3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангаагүй 1 зөрчилд албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

Тайлант хугацаанд www.shilendans.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 161 мэдээлэл, хугацаа болоогүй 1 мэдээлэл, хугацаа хоцроосон 9 мэдээлэл байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар орлого, зардлын төлөвлөлт, биелэлтийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1..Программ хангамжийн талаар

1.1. Илрүүлэлт:

Тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программ хангамжаас мөнгөн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, журналын харилцагч болон харьцсан дансаар татагдах боломжгүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан хэрэглэгчдийг буруу мэдээллээр хангах

1.3. Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжид сайжруулалт хийх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.03.15	Аудитын нэр: Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/85/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК	Сая төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программ хангамжаас мөнгөн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, журналын харилцагч болон харьцсан дансаар татагдах боломжгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Нягтлан бодогч	Л.Цэнгүүнжав Ё.Мөнхбаяр
2	Тайлант хугацаанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 161 мэдээлэл, хугацаа болоогүй 1 мэдээлэл, хугацаа хоцроосон 9 мэдээлэл байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Гүйцэтгэх захирал Нягтлан бодогч	Л.Цэнгүүнжав Ё.Мөнхбаяр
ДҮН		-			